



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Д.САРАНГЭРЭЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2019. 03. 29 № 09

Асуулга тавих тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулах хуультай.

Уг хуулийн дагуу Засгийн газар жил бүр эрүүл мэндийн даатгалын хувь хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан шинэчилж тогтоодог. Үүний дагуу эрүүл мэндийн даатгалын жилийн хураамж 2016 онд 46080, 2017 онд 57600, 2018 онд 28800, 2019 онд 38400 мянган төгрөг болсон. Эрүүл мэндийн зайлшгүй төлөх албан журмын даатгалтай холбоотойгоор даатгалд хамрагдах иргэдийн тоо жил ирэх тусам буурч байгаа гэсэн мэдээлэл байна.

Иймд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулснаар даатгалд хамрагдах иргэдийн тоо хэрхэн өөрчлөгдсөн, улсын хэмжээнд даатгалд хамрагдалтын одоогийн бодит нөхцөл байдлын талаар Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, мөн хуулийн 33.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуулгыг Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл Танд хандан тавьж байна. Үнд:

1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулснаар эрүүл мэндийн даатгалд хамрагдах иргэдийн тоо, хэмжээнд зөрөг болон сөрөг ямар өөрчлөлт орсон талаар;
2. Монгол Улсын хэмжээнд эрүүл мэндийн даатгалд хамрагдсан болон хамрагдаагүй иргэдийн тоо, хувь нийслэл, аймаг, сум, дүүргийн хэмжээнд ямар байгаа талаар;
3. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа иргэдийн нийтлэг шалтгаан, үндэслэлүүдийн талаар;
4. Иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хэмжээг хэрхэн сайжруулах арга замын талаар;
5. Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдийг "Элэг бутэн Монгол" хөтөлбөрт хэрхэн хамруулах арга замын талаар тодорхой хариуг боловсруулж ирүүлнэ үү.

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хувийг: Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Лазарт

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

С.БЯМБАЦОГТ



0000000034